

БАТЛАВ. “ГҮНИЙ-УС” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ж.ЭНХЧИМЭГ

### АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

<b>Байгууллагын нэр</b>	<b>Хэсгийн нэр</b>	
“Гүний-ус” ХХК	Инженер техникийн хэсэг	
<b>Ажлын байрны нэр</b>	<b>Хавсран гүйцэтгэх ажил</b>	<b>Дугаар</b>
Сүлжээний техникч	ААНБ хариуцсан байцаагч	<sup>1</sup> .....
<b>Шууд харьяалагдах ажлын байр</b>	<b>Шууд харьяалах албан тушаал</b>	
Гүйцэтгэх захирал	Хэсгийн бүх ажилчид	
<b>Ажлын байрны зорилго</b>	Компанийн зорилт, эрхэм зорилгыг эрхэмлэн ажиллах	

#### 1. Ажлын байрны үндсэн чиг үүрэг

1. Байгууллагаас зохиосон мэргэжлийн болон бусад арга хэмжээнд идэвхитэй оролцох, шаарлагатай тохиолдолд үйлдвэрийн аль ч объектод ажил амралтын ямарч нөхцөлд бэлэн байхын зэрэгцээ, ээлжийн амралтаа зохицуулан илүү цагаар ажиллах
2. ХХАА-ны үе шатны зааварчилгууд, нийтийн аж ахуйн салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, стандартыг ажилдаа мөрдлөг болгон осол, аваар зөрчилгүй ажиллах
3. Хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгыг мөрдөн ажиллах
4. Ажил үйлдвэрлэлийн технологийн горимыг хатуу баримталж, ажлын бүтээмжийг өндөр байлгах, ажлын цагийг баримтлах, ажлын байр орхин дур мэдэн орхих, чөлөө зөвшөөрөлгүй явах, ажил таслах, чөлөөний хугацаа хэтрүүлэх, ажилтан болон бусдад сөрөг нөлөөлөл учруулахгүйгээр ажиллаж, хөдөлмөрлөх
5. Үйлдвэрлэлийн осол, гэмтэлд өортөхгүй байхын тулд мөрдөж ажиллах “БҮҮ МАРТ-10” зарчмыг ажилдаа хэвшүүлж ажиллах
6. Өөрийн мэдлэг, мэргэшил, ур чадварыг байнга төлөвлөлтэйгээр хөгжүүлж, сорилын болон улирал тутамд зохион байгуулагдах мэргэжлийн, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шалгалтанд манлайлж ажиллах
7. Хууль журам, дүрэм, стандарт, заавар, зааварчилгыг уншин судлан, өөрийн болгож улирал тутам мэргэжлийн сургалт, шалгалтанд хамрагдаж ажиллах
8. Байнгын болон орон тооны бус комисс, ажлын хэсэгт ажиллах ба ажлын гүйцэтгэлийн хэрэгжилтийг ханган үр дүнг удирдлагад тайлагнаж, мэдээ тайланг гаргаж ажиллах
9. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах ба Цэвэр бохир усны техникийн бүлэг, Уст цэгийн хамгаалах бүлгийн бие бүрэлдэхүүнд бэлэн байхын зэрэгцээ хээрийн сургууль, дадлага сургууль, өндөржүүлсэн буюу онц байдал зарласан үед шуурхай арга хэмжээ авч, удирдлага, зохион байгуулалтаар хангагдан ажиллах
10. Учирч болзошгүй эрсдэлээс сэрэмжлэн, аюулыг мэдээлж, илэрсэн зөрчил, гэмтлийг тухай бүрт нь мэргэжлийн ажилчинаар засварлуулан ажиллах
11. Ажлын байран дахь цахилгааны болон галын аюулгүй байдлыг ханган ажиллах
12. Ажил үүрэг гүйцэтгэж буйгаа ээлжийн диспетчерт заавал мэдэгдэж, бүртгүүлж ажиллах

## 2. Ажлын байранд хийгдэх ажлууд:

<ol style="list-style-type: none"> <li>1. Инженерийн шугам сүлжээний тасралтгүй ажиллах нөхцлийг хангах зорилгоор гүний худгуудийн носас ажиллуулах горимыг мөрдөж ажиллах</li> <li>2. Ус хэрэглэгч барилгын ажил гүйцэтгэгч байгууллагуудтай нягт холбоотой ажиллаж, ус нээх хаах, тоолуур суурилуулах ажлыг хянаж, хяналтын тоолуурийн холбоотой бичиг баримтыг хуулбарлан авч гэрээ байгуулж ажиллах</li> <li>3. Хэрэглэгчдийн цэвэр бохир усны худгийн хаалт, армотур, люк таг, шугам сүлжээнд усны алдагдал байгаа эсэхийг үзэж шалган, ээлжийн диспетчерт мэдэгдэн цаг алдалгүй зөрчлийг арилгуулах</li> <li>4. Дулааны цахилгаан станцын хөргөлтийн системийг шаардлагатай үед хотын усан хангамжийн системээс удирдлагын шийдвэрээр хангах</li> <li>5. Төвлөрсөн системд холбогдсон албан газар аж ахуйн нэгжийн усны хэрэглээг сар бүрийн 25-ны дотор нэгтгэж гаргаж өгөх</li> <li>6. Цэвэр усны тоолуур суурилуулах болон гадна байдлын үзлэг шалгалт хийх, битүү байдлыг турших, лацдах, тоолуурын тоон системийг унших, засварлах, баталгаажуулах</li> <li>7. Усны хэмжүүр нь эвдэрсэн, баталгаат лац байхгүй, ус хулгайгаар хэрэглэсэн, гэрээ зөрчсөн иргэд, аж ахуйн нэгж, усан санч нарын зөрчлийг удирдлагад мэдэгдэн цаг алдалгүй асуудлыг шийдвэрлүүлэх.</li> <li>8. Төвлөрсөн системд холбогдсон айл өрхийн байцаагч нарын ус хэмжүүрийн тоолуурын заалтанд хяналт тавих, үзлэг шалгалтыг улиралд нэг удаа хийж, үр дүнг удирдлагуудад тайлагнах, зөрчлийг арилгуулах.</li> <li>9. Ажлын багаж төхөөрөмж, сак, гагнуурын аппарат зэргийн бүрэн бүтэн байдлыг хангаж, шугам сүлжээнд гэмтэл, осол аваар гарсан тохиолдолд гагнуурын ажлыг чанартай хийж гүйцэтгэх,</li> <li>10. Барилга угсралт, үйлдвэрийн ус хэрэглээнд хяналт тавих</li> <li>11. Сар бүрийн 06-наас 20-ний хооронд албан газруудын ус хэрэглээнд бичилт хийж, 20-ноос 25-ний хугацаанд борлуулагдсан усны төлбөр тооцоог барагдуулж, өр авлага үүсгэхгүй байх тал дээр ерөнхий санхүүчтэй байнгын уялдаа холбоотой ажиллах.</li> <li>12. Хэрэглэгч үйлчилгээний менежерийн эзгүйд дуудлаг, засвар үйлчилгээний ажлыг хариуцан ажиллах</li> <li>13. Тоолуурын стенгийн арчилгаа, баталгаажуулалтын ашиглалтын үеийн аюулгүй байдлыг ханган ажиллах</li> </ol>
---

## 3. Ажлын байранд тавигдах шаардлагууд:

	Мэргэжил	техникч
	Боловсрол	Дунд
<b>Ерөнхий шаардлага</b>	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Харилцааны болон хамтран ажиллах чадвартай</li> <li>• Мэдээ, мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх чадвартай</li> <li>• Мэргэжлийн түвшинд дадлагажсан</li> <li>• Удирдан зохион байгуулах чадвартай</li> </ul>
		<ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд тогтмол хамрагдаж ажиллах</li> </ul>

<b>Тусгай шаардлага</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Эд хөрөнгө эзэмших гэрээг аж ахуйн няравтай байгуулж ажиллах</li> </ul>	
<b>Ажлын байрны нөөц хэрэгсэл</b>	Санхүү	<ul style="list-style-type: none"> <li>• Албан тушаалын цалин, ур чадварын нэмэгдэл, бусад нэмэгдэл, нөхөн төлбөр, тусламж, тэтгэмж, урамшуулал, мэргэжлийн чиглэлээр сургалт, семинарт хамруулах</li> <li>• Монгол улсын хэмжээнд мөрдөж байгаа Засгийн Газраас тогтоосон Хөдөлмөрийн хөлсний өөрчлөлтийг мөрдөж ажиллах</li> <li>• Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалыг хариуцах</li> </ul>
	Ажлын байр	<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөр хамгаалах хувцас, багаж хэрэгслээр хангах.</li> <li>• Ажлын өрөө, ширээ, сандал</li> <li>• Бичгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж</li> <li>• Ажил үйлчилгээний зориулалттай гар утасны нэгж олгоно</li> <li>• Унаанд нь шатахуун /лимитээр/ олгоно</li> <li>• Гэнэтийн ослын даатгалд даатгуулж ажиллана</li> </ul>
<b>Ажлын байрны нөхцөл:</b> Хэвийн		
<b>Ажлын байрны нэр:</b> Сүлжээний техникч		

#### 4. Ажлын байрны тодорхойлолт

<p style="text-align: center;"><b>Боловсруулсан:</b></p> <p style="text-align: center;">Хүний нөөцийн менежер:</p>	<p style="text-align: center;"><b>Хянасан:</b></p> <p style="text-align: center;">Ерөнхий инженер: ..... /С.Отгончулуун/</p>
--	--